



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 259

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мастер инвестмент менежмент ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 50,000,000 /тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Мастер инвестмент менежмент ҮЦК” ХХК /Ц.Дашцэрэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн
25.9.-р тогтоолын хавсралт

“Мастер инвестмент менежмент ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээнд оруулах өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр, /Регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ/₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/	Хувьцааны тоо	Үнийн дүн/₮/	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/
1	Ц.Дашцэрэн /РД: ЕС72052331/	10,000₮	20,000	200,000,000	100%	5,000	50,000,000	25,000	250,000,000	100%
	Нийт		20,000	200,000,000	100%	5,000	50,000,000	25,000	250,000,000	100%